



ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР ДАХЬ ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

“Ховдын толь” ТББ нь 2015 онд Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-ын санхүүжилт болон арга зүйн дэмжлэгтэйгээр Ховд аймгийн Дарви суманд орших Хөшөөтийн нүүрсний ордод үйл ажиллагаа явуулж байгаа МонЭнКо ХХК болон Ховд аймгийн хооронд байгуулагдсан Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийж ажиллалаа. “Хөшөөт төслийн хяналт, иргэдийн оролцоо” төслийн хүрээнд хэрэгжсэн энэхүү мониторингоор дэд бүтцийг хөгжүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах талаарх талуудын үүргийн хэрэгжилтийг үнэлэв. Мониторингоор гэрээний хэрэгжилттэй холбоотой зөрчил дутагдал, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, орон нутгийн иргэдийн оролцоог ханган, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах замаар цаашид гэрээ, түүний хэрэгжилт, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж гаргалаа. Уг мониторингийн дүнг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж олон нийтэд хүргэхийн сацуу гэрээний талуудтай уулзалт хийж үр дүнг нь танилцууллаа.

Ховд аймаг болон МонЭнКо ХХК нь 2016 оны эцсээр дээрх гэрээг шинэчлэх гэж байгаатай холбоотойгоор мониторингийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлд үргэлжлүүлэн нөлөөллийн ажил хийхээр төлөвлөж байна.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Ашигт малтмалын тухай хуульд 2006 онд оруулсан өөрчлөлтөөр тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутагт байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтэц хөгжүүлэх асуудлаар гэрээ байгуулан үүрэг хүлээсэн. Гэхдээ гэрээнд иргэний нийгэм, иргэдийн оролцоог орхигдуулснаас орон нутагт энэ нь харилцан адилгүй хэрэгжиж байна. Ерөнхийдөө гэрээ байгуулахгүй байх, байгуулсан ч хэрэгжүүлэхгүй, эсвэл нутгийн иргэдийн нийтлэг эрх ашгийг зөрчсөн нөхцөлүүд тусгах зэрэг дүр зураг харагдаж байгаа юм.

Ховд аймгийн хувьд ч гэрээний мэдээлэл олон нийтэд ил тод бус, хэрэгжилтийг хянах явцад иргэдийн оролцоо байхгүй төдийгүй аймгийн зүгээс гэрээнийхээ хэрэгжилтийг бодитойгоор үнэлж, хяналт тавих чадавх сул байгаа нь мониторингоор харагдлаа. Тухайлбал, төсөлд шаардлагатай бараа ажил, үйлчилгээ, ажиллагсдын тоо зэрэг гэрээний хэрэгжилтийг хянахад шаардлагатай мэдээлэл судалгаа, тоо бүртгэл хөтөлдөггүйгээс зөвхөн компани буюу нэг талын тайлан мэдээлэлд тулгуурлан хэрэгжилтийг үнэлж ирсэн нь учир дутагдалтай юм. Түүнчлэн гэрээг байгуулахдаа аймгийн зүгээс тооцоо судалгаа хийгээгүй, холбогдох мэргэжлийн болон судалгааны байгууллагын төлөөллийг оролцуулаагүйгээс гэрээнд анхнаасаа бүрэн хэрэгжих боломжгүй заалтууд тусгагдсан нь гэрээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлжээ.

Гэрээний тодорхой заалтуудтай холбоотой мониторингийн дүнг доор товчлон харуулав.



1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Хамтран ажиллах гэрээний холбогдох заалтууд

Компани нь байгаль орчныг хамгаалах талаар Ашигт малтмалын тухай хуулийн 35, 37 дугаар зүйлийн биелэлтийг хангаж ажиллана.

Компани нь байгаль орчныг нөхөн сэргээх төлөвлөгөөний хүрээнд хөрс хуулалт хийсэн талбайтай тэнцэхүйц хэмжээний газарт дүйцүүлэн ойжуулалт хийх ба уг газрын байршлыг Ховд аймаг тогтооно.

Компани нь усны нөөцийг зохистой ашиглах үүднээс Төслийн үйл ажиллагаанд үйлдвэрлэлийн болон уурхайн тоосжилт дарах зориулалтаар газрын гүний усыг аль болох хэрэглэхгүй байх, гадаргын усыг хуримтлуулах замаар хиймэл нуур, цөөрмийг бий болгон үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглах боломжийг цаашид судалж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хамтран ажиллах гэрээний 11.1, 11.2, 11.6 дахь заалтууд

- МонЭнКо компани Ашигт малтмалын тухай хуулийн 35, 37 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг болон байгаль орчныг хамгаалах үүргээ хэрэгжүүлэх талаар зохих хүчин чармайлт гарган Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ ба Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Гэхдээ гэрээний дагуу хүлээсэн усны нөөцийг зохистой ашиглах буюу гадаргын усыг хуримтлуулан үйлдвэрлэлд ашиглах үүргийн хэрэгжилт хангалтгүй байв. Гадаргын усыг хуримтлуулах ажил одоог хүртэл огт хийгдээгүй бөгөөд үйлдвэрлэлийн хэрэглээний болон тоосжилт дарах бүх усыг Хөшөөт голоос шууд авч хэрэглэсээр байгаа нь гадаргын усны нөөцийг улам бүр хомсдуулж, цаашид гүний усны нөөцөд нөлөөлөх сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй байна.
- Жил бүр хөрс хуулалтын талбайтай тэнцэх хэмжээний газарт дүйцүүлэн ургамалжуулалт хийх үүрэгтэй боловч төслийн санхүүгийн байдлаас хамааран одоогийн байдлаар хөрс хуулалт хийсэн нийт 30 га газрын дөнгөж 13.3 орчим хувь буюу 4 га газарт л ургамалжуулалт хийгджээ.

2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Компани орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор 2014 онд Ховд Хөшөөт хөгжил санд 600 сая төгрөгийг төвлөрүүлэх ба үүнд экспортлосон нүүрс 200 000 тонн хүрсэн тохиолдолд 300 сая, 500 000 тонн хүрсэн тохиолдолд 300 сая төгрөгийг тус тус төвлөрүүлнэ.

2014 онд Хөшөөтийн уурхайгаас экспортлосон нүүрсний хэмжээ 100 000 тонн хүрсэн үеэс эхлэн 1 тонн тутмаас 0,6 ам.доллар, экспорт эхэлснээс хойш 9 дэх сараас эхлэн экспортлосон нүүрсний хэмжээ сар тутам 100 000 тонноос давах тохиолдолд 1 тонн тутмаас 1 ам.долларыг Ховд Хөшөөт хөгжил санд тус тус төвлөрүүлж, орон нутгийн хөгжилд зарцуулна. Хэрэв тухайн сард экспортлосон нүүрсний хэмжээ 100 000 тоннд хүрээгүй бол 1 тонн тутмаас 0.6 ам.доллараар тооцож тус санд төлнө.

2015 онд Ховд Хөшөөт хөгжил санд 1 тэрбум төгрөгийг төвлөрүүлэх ба үүнд 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн экспортлосон нүүрс 500 000 тонн хүрсэн тохиолдолд 500 сая, 1 000 000 тонн хүрсэн тохиолдолд 500 сая төгрөгийг тус тус төвлөрүүлнэ.

Экспортлосон нүүрсний тоо хэмжээг Монгол Улсын гаалийн байгууллагын албан ёсны бүртгэл баримтад үндэслэн тооцох ба Талууд сар бүрийн эцсээр тооцоо нийлж, экспортлосон нүүрсний хэмжээг тогтооно.

Ховд Хөшөөт хөгжил санд төвлөрүүлэх хөрөнгө нь 2014, 2015 онуудад хамаарах ба харин 2016 онд уг санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тухайн үеийн зах зээлийн нөхцөл байдлаас хамааран Талууд хэлэлцэн тохирч тогтооно.

Талууд Ховд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зорилгоор Ховд Хөшөөт хөгжил санг хамтран үүсгэн байгуулж, сангийн ажиллах журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж мөрдөж ажиллана.

Хамтран ажиллах гэрээний 14.5 - 14.11 дэх заалт



- Талууд гэрээгээр хүлээсэн орон нутгийн хөгжлийг дэмжих үүргээ хэрэгжүүлэх талаар тодорхой санаачилга гаргаж, Ховд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Ховд Хөшөөт хөгжил санг 2015 онд байгуулжээ.
- Компанийн болон аймгийн хамтарсан ажлын хэсэг Хөшөөт төслөөс 2014-2015 онд дээрх санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг уурхайн нийт экспортын хэмжээнд тулгуурлан 2015 оны эцсээр дахин тооцож 329.0 сая төгрөг байхаар тогтоожээ. Харин 2016 оны эхний 9 сарын байдлаар 253.0 сая орчим төгрөг төвлөрүүлсэн байна. Ийнхүү төвлөрүүлсэн хөрөнгө нь төлөвлөсөн хэмжээнээс бага байгаа шалтгааныг Компанийн зүгээс олон улсын зах зээл дээр бүтээгдэхүүний үнэ буурч, төлөвлөгөө тасалдсантай холбон тайлбарлаж байгаа юм. Гэхдээ мониторингийн багаас Ховд Хөшөөт хөгжил санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг гэрээний заалтад үндэслэн нарийвчлан тооцоход хамгийн багадаа 1.5 тэрбум болж байгаа нь Ажлын хэсгийн тогтоосон хэмжээнээс даруй 4.5 дахин их байна. Хэдийгээр тухайн үеийн уул геологийн нөхцөл, зах зээл дэх бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт зэргээс шалтгаалан уурхайн олборлолт, экспортын хэмжээ буурч болохыг үгүйсгэхгүй ч гэрээнд анх тусгасан үйлдвэрлэл, экспортын тоо хэмжээ нь компанийн бодит үйл ажиллагаа, экспортын хэмжээнээс хол зөрүүтэй байгаа юм. Үүнээс үзэхэд Ховд Хөшөөт хөгжил санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг анх тооцохдоо ордын нөөц, түүний үнэлгээ, төслийн Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), олборлолт борлуулалтын төлөвлөгөө, тайланг сайтар нягтлан судалж, бодитой тооцоо хийгээгүйгээс угаасаа хэрэгжих боломжгүй заалтыг гэрээнд тусгасан байна.
- Нөгөө талаар Хөшөөтийн уурхайн ТЭЗҮ анх батлагдсанаас хойш 5 жил өнгөрч, уурхайн техник технологи, хүчин чадалд томоохон өөрчлөлт орсон ч өнөөг хүртэл нэмэлт тодотгол хийгдээгүй байна. Энэ нь холбогдох хууль тогтоомжийг зөрчиж байгааг Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас тогтоож, ТЭЗҮ-д нэмэлт тодотгол хийлгэх шаардлагыг компанид хүргүүлж байжээ. Үүний дагуу Компани ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулсан гэж мэдэгдэж байгаа боловч нэмэлт тодотгол хийгдсэн ТЭЗҮ-ийн баталгаат хувийг аймгийн ИТХ, ЗДТГ-т өнөөг хүртэл ирүүлээгүй байна.

Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мах, сүү, хүнсний ногоо, ус, ажлын хувцас, автобус болон жижиг машины түрээсийн үйлчилгээ, харуул хамгаалалт, гурилан бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн болон бусад бараа, ажил, үйлчилгээний 50-иас доошгүй хувийг орон нутгийн аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх замаар орон нутгийн жижиг, дунд бизнесийг дэмжин чадавхжуулах чиглэлээр Талууд хамтран ажиллана.

Төслийн бараа, ажил үйлчилгээний ханган нийлүүлэхэд тухайн бизнес үйлчилгээний шаардлага хангасан орон нутгийн аж ахуйн нэгжүүд давуу эрхтэйгээр оролцох ба компанийн зүгээс тавигдах шаардлагыг хангасан нөхцөлд тэдгээртэй гэрээ байгуулж ажиллана.

Хамтран ажиллах гэрээний 14.2 дахь заалт

- МонЭнКо ХХК нь 2014-2015 онд Ховд аймгийн 34 аж ахуйн нэгж, 5 иргэнтэй хамтран ажиллаж, 2015 оны 9 сарын байдлаар нийт 7.5 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авснаар гэрээний 14.2 дахь заалтаар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн гэж 2 талын хамтарсан ажлын хэсэг дүгнэжээ.¹ Гэхдээ Аймгийн ЗДТГ-ын зүгээс гэрээний хэрэгжилтийг хянах, үнэлэхэд шаардлагатай бүртгэл, тооцоо судалгаа хөтөлдөггүй, зөвхөн компанийн өгсөн мэдээлэлд тулгуурлан гэрээг дүгнэдэг нь учир дутагдалтай юм. Хөшөөт төслийн бараа ажил үйлчилгээний нийт дүн болон түүнд эзлэх орон нутгийн аж ахуйн нэгжийн ханган нийлүүлэлт, ажил гүйцэтгэлийн дүнг гэрээг хэрэгжүүлэгч хоёр талын аль аль нь (нэн ялангуяа Ховд аймаг) жил, жилээр нарийвчлан тооцож дүгнэхгүйгээр гэрээний дээрх заалтын хэрэгжилтийг бодитойгоор үнэлэх боломжгүй юм.



Тээвэрлэлтийн ажлын 50-иас доошгүй хувийг Ховд аймгийн тээврийн байгууллагаар гүйцэтгүүлэх ба тээврийн хэрэгслүүд нь тээвэрлэлтийн нөхцөлд тохирсон, техникийн чанарын баталгаатай бөгөөд орон нутгийн тээвэрчдийн төлөөллийг оролцуулсан, албан ёсны бүртгэлтэй аж ахуйн нэгж байна. Үүнд Компанийн Ховд аймагт бүртгэлтэй тээврийн хэрэгслүүд багтана. Тээвэрлэлт хийх аж ахуйн нэгжүүдийг аймгийн Тээвэр, авто замын газраас бүртгэлжүүлнэ.

Хамтран ажиллах гэрээний 14.4 дэх заалт

- МонЭнКо компаниас 2014, 2015 онд Ховд аймгийн Авто тээврийн төвтэй хамтран ажиллаж, экспортын нүүрс тээвэрлэлтийг орон нутгийн таван компаниар гүйцэтгүүлсэн нь төслийн нийт ачаа тээврийн 90 гаруй хувийг эзэлж байна гэж мэдээлжээ. Гэсэн ч аймгийн Авто тээврийн газар болон холбогдох бусад байгууллагад уг мэдээллийг харьцуулан шалгах бүртгэл, тооцоо мөн л байхгүй байлаа. Үүнээс харахад гэрээний энэхүү заалтыг ч мөн бүрэн хэрэгжсэн гэж үзэхэд эргэлзээтэй байна.

3. АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Төслийн хүрээнд ажиллах нийт Монгол ажилчдын 70-аас доошгүй хувийг Ховд аймгийн иргэдээс бүрдүүлнэ.

Хамтран ажиллах гэрээний 14.3 дахь заалт

- “Хөшөөт төсөлд 2014 онд нийт 1100 гаруй хүн ажилласны 70 хувь нь орон нутгийн иргэд байсан” тухай Компанийн тайлан мэдээнд үндэслэн талууд дээрх заалтыг бүрэн хэрэгжсэн гэж үзжээ. Гэтэл компанийн нийт ажилтны тоо, түүний дотор орон нутгийн иргэдийн эзлэх хувь хэмжээний талаар хоорондоо зөрүүтэй мэдээлэл байгаа бөгөөд ЗДТГ болон гэрээний хэрэгжилтийг хариуцсан ажлын хэсэгт тэдгээрийг харьцуулан шалгах бүртгэл мэдээлэл байхгүй байгаа нь гэрээний дээрх заалтыг бүрэн хэрэгжсэн гэж үзэхэд эргэлзээ төрүүлж байна. Тухайлбал, 2015 оны 7-8 дугаар сард МоЭнКо компаниас Ховд аймгийн Хөдөлмөрийн хэлтэст ирүүлсэн мэдээллээр 2014-2015 онд орон нутгаас 200 гаруй хүн авч ажиллуулсны 90 гаруй хувь нь 3-4 сарын хугацаагаар ажилласан түр ажилтнууд байсан бол², 2015 оны 9 сарын байдлаар орон нутгаас 60 гаруй хүн л үндсэн ажилтнаар ажиллаж байсан тухай мэдээлэл бас байгаа юм.³ Харин Ховдын толь ТББ-д Компаниас ирүүлсэн мэдээллээр 2015 оны 10 сарын байдлаар төсөлд нийт 742 хүн ажиллаж байгаагийн 240 гаруй нь сул зогсолтод хамрагдаж, үндсэн цалингийн 60 хувиар цалинжиж байжээ.⁴

Компани нь Ховд хотын ногоон байгууламжийг дэмжиж, Номингийн 4 замын уулзвараас Бичигтийн пост хүртэлх замын 2 талыг ногоон байгууламж, хамгаалалтын хашаа, гэрэлтүүлэг, явган хүний замтай иж бүрэн хэлбэрээр тохижуулах ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэнэ.

Хамтран ажиллах гэрээний 14.18 дахь заалт

1 Гэрээний 2014 оны болон 2015 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг дүгнэсэн баримт бичиг
 2 МоЭнКо компаниас Ховд аймгийн Хөдөлмөрийн хэлтэст өгсөн 2015 оны 8 дугаар сарын мэдээ
 3 МоЭнКо компаниас Ховд аймгийн Хөдөлмөрийн хэлтэст өгсөн 2015 оны 10 дугаар сарын мэдээ
 4 Ховдын толь ТББ-ын мэдээлэл хүссэн 06/58 дугаар албан бичгийн хариуд МоЭнКо компаниас 2016 оны 1 дүгээр сард ирүүлсэн мэдээлэл



- МонЭнКо ХХК нь гэрээний дээрх заалтыг хэрэгжүүлэхээр 140.0 сая төгрөгийг Ховд Хөшөөт хөгжил санд шилжүүлжээ. Аймгийн ЗДТГ-тай байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр “Ховд эрч хүч” орон нутгийн өмчит компани энэ ажлыг гүйцэтгэсэн боловч гүйцэтгэл нь чанар, хэмжээний хувьд маш хангалтгүй болсон байна. Тухайлбал, нийт 1300 метрийн урттай замын зөвхөн 550 метрт замын хоёр талаар төмөр хашлага хийсэн ба явган хүний замыг хагас дутуу, ногоон байгууламжийг огт хийгээгүй байна. Үүнийг гүйцэтгэгч компани болон захиалагч тал болох аймгийн ЗДТГ-ын хяналт, хариуцлагаас шалтгаалсан гэж үзэхээс өөр аргагүй юм.

4. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ, ҮНЭЛЭХ ҮЙЛ ЯВЦ, ТҮҮНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ

Ховд аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар нь төслийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд дэмжиж, ард иргэдэд үнэн бодит мэдээлэл өгч, төслийн талаарх мэдээллийг улирал тутамд Засаг даргын зөвлөл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж, шаардлагатай арга хэмжээ авч байна.

Хамтран ажиллах гэрээний 8.1 дэх заалт

- Төслийн талаар иргэдэд мэдээлэл өгөх, гэрээний хэрэгжилттэй холбоотой мэдээллийг ил тод болгох тодорхой арга хэмжээ аваагүй, гэрээний эх бичвэрийг ч олон нийтэд ил тод болгоогүй байна. Мониторингийн хүрээнд хийгдсэн гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийн ил тод байдал, хүртээмжийн судалгаанд оролцсон 250 иргэний 94 хувь буюу 235 нь уг гэрээний талаар огт мэдэхгүй гэж хариулсан бол цөөн тооны хүн зөвхөн сураг сонссон төдий мэдээлэлтэй байв.
- МоЭнКо ХХК-аас гэрээний хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа тайланг сар, улирал тутамд гаргаж, Ховд аймгийн ЗДТГ, ИТХ, гэрээний хэрэгжилтийг хариуцсан ажлын хэсэгт ирүүлдэг байна. Гэхдээ энэ тайланг зөвхөн цөөн тооны албан тушаалтнууд уншиж танилцдаг бөгөөд Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчдээр улирал тутамд хэлэлцүүлж хэвшээгүй байна.
- Гэрээний хэрэгжилтийг хянах ажлын хэсэг 2014 онд байгуулагдсан ч гэрээг зохих тоо бүртгэл, тооцоо баримтад суурилан бодитойгоор үнэлж дүгнэж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, компанийн ажиллах хүчин болон ханган нийлүүлэлтийн төлөвлөгөө, санхүүгийн бүртгэл тооцоо, олборлосон, борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ зэрэг гэрээг дүгнэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, бүртгэл тооцоо байхгүйгээс зөвхөн нэг талын буюу компанийн ирүүлсэн тайланд үндэслэн гэрээг дүгнэсээр иржээ.
- Төслийн хэрэгжилтийн явцад мэргэжлийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хяналтыг үе шаттайгаар хийлгэх тухай заалт гэрээнд бий боловч 2014 онд байгуулагдсан дээрх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд иргэний нийгмийн төлөөлөл ороогүй бөгөөд энэхүү мониторингоос өмнө иргэний нийгмийн байгууллагаас гэрээний хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийсэн тохиолдол байхгүй байна.
- Ховд аймгийг төлөөлөн компанитай хэлэлцээр хийх, гэрээний төслийг боловсруулах ажлын хэсгийн ахлагч нь одоо гэрээний хэрэгжилтэд хяналт тавих Ажлын хэсгийг ахалж байгаа нь (2016 оны 8 сар буюу сонгуулийн дараа албан тушаал өөрчлөгдөх хүртэл) гэрээний хэрэгжилтийг бодитойгоор үнэлж дүгнэх боломжийг бууруулж байна. Учир нь гэрээ байгуулах үйл явц нь ил тод бус, иргэний нийгмийн хөндлөнгийн хяналт оролцоогүйгээр явагдсан энэ нөхцөлд гэрээ байгуулсан албан тушаалтан өөрөө гэрээний хэрэгжилтийг хянах нь зохисгүй бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүйг анхаарах шаардлагатай юм.



ЗӨВЛӨМЖ

А. Ил тод байдал, иргэдийн оролцоог хангах чиглэлээр

- Мэдээллийг ил тод болгоход анхаарал хандуулж гэрээний эх бичвэр, түүний хэрэгжилтийн мэдээллийг Ховд аймгийн болон Компанийн албан ёсны цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд тогтмол хүргэх;
- 2016 онд гэрээг шинэчлэн батлахдаа гэрээний төсөл боловсруулах, түүний хэрэгжилтийг хянах Ажлын хэсэгт иргэний нийгэм, төслийн нөлөөлөлд өртөж буй сумдын иргэдийн төлөөллийг оролцуулж, гэрээний төсөлд олон нийтийн санал авах уулзалт, хэлэлцүүлгийг өргөнөөр зохион байгуулах;
- Гэрээнд иргэдийн оролцоог хангахад 2016 оны 7 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Захиргааны ерөнхий хууль болон мөн онд Засгийн газраас баталсан Хамтран ажиллах гэрээний загварт тусгагдсан иргэдийн оролцооны журмыг мөрдөн хэрэгжүүлэх;
- Компанийн зүгээс гэрээний үүргээ хэрэгжүүлэхэд улам анхаарч, огт хэрэгжихгүй байгаа үүрэг буюу ОУИТБС-ын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж нийтэд мэдээлэх зэрэг үүргээ хэрэгжүүлэхэд анхаарах.

Б. Гэрээний хэрэгжилт, түүнд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр

- Гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах зорилгоор Ховд аймгийн зүгээс төслийн хөрс хуулалт, байгаль орчны нөхөн сэргээлт, уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, олборлолт, борлуулалтын хэмжээ, ажиллах хүчин, тээвэр, ханган нийлүүлэлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл зэргийн талаар нарийн бүртгэл тооцоо хөтөлж мэдээллийн сан бүрдүүлэх, зөрүүтэй мэдээллийг нягтлан шалгах замаар гэрээний хэрэгжилтийг бодитойгоор үнэлж байх;
- Байгаль орчныг хамгаалах, усны нөөцийг зохистой ашиглах үүргийн хэрэгжилтийг хангах үүднээс Хөшөөт төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хараат бус хөндлөнгийн мониторинг үнэлгээ хийлгэх;
- Гэрээний 12.5 болон 14.1 буюу хугацаа хэтэрсэн заалтуудыг хэрэгжүүлэх талаар олон нийтийн оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулж, тодорхой шийдэлд хүрэх.

В. Ховд Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр

- Ховд Хөшөөт хөгжил санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг төслийн шинэчилсэн ТЭЗҮ, үйлдвэрлэл, борлуулалтын тооцоо, төлөвлөгөөнд суурилан бодитой тогтоох;
- Гэрээ байгуулах Ажлын хэсэгт дээрх асуудлаар тооцоо судалгаа хийх чадвар бүхий мэргэжлийн хүмүүс, холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулах;
- Ховд Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр гүйцэтгэж буй ажлын чанар, үр нөлөөг сайжруулах үүднээс сонгон шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу, ил тод, нээлттэй явуулж, иргэний нийгмийн оролцоотойгоор үнэлж дүгнэдэг болох зэрэг арга хэмжээ авахыг тус тус зөвлөж байна.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамъян гүний гудамж -5/1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 14240,
Утас: (976-11) 313207
Факс: (976-11) 324857

Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилт, арга зүйн дэмжлэгтэйгээр төрийн бус байгууллагууд мониторинг хийдэг билээ. Мониторингийн гол үр дүнг энэхүү МОНИТОР цувралаар олон нийтэд хүргэхийн сацуу уг ажлыг цаашид боловсронгуй болгох чиглэлээр төрийн бус байгууллагууд үргэлжлүүлэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг юм.